



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/57/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:
tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.19 № 2/34
танай _____-ны № _____-т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод

2519044

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Н.Дэмбэрэлд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны 2019 оны 01 дүгээр сарын 30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 18-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 16/58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрдэнэцогт сумын ИТХурал нь Иргэдийнхээ эрх ашиг, хүсэл сонирхлыг илэрхийлж, сум орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэн, иргэн, хамт олны бүтээлч санаачилга, идэвхтэй оролцоог эрхэмлэн дэмжиж иргэддээ тулгуурласан чадавхтай, хариуцлагатай нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, иргэдийнхээ ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Сонгогч иргэддээ ойртон нэгдэж, ИТХ-ын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлж, гарсан шийдвэр, дэвшүүлсэн зорилтынхоо биелэлт, үр дүнг хянаж шинжилдэг ажлаа эрс сайжруулах.
- Хурал түүний тэргүүлэгчид, хороо, төлөөлөгчид үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд шуурхай явуулж гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах түүний биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлнэ.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 61,1 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилгүй, 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Аудитын явцад санхүүгийн тайланд илэрхийлээгүй ХХОАТ-хөнгөлөлтийн буцаан олголтын зөрүү 163,0 мянган төгрөгийн өглөг, татварт илүү тооцож шилжүүлсэн 96,9 мянган төгрөгийн авлага нийт 259,9 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд хийлгэлээ.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 61,7 сая төгрөгийн төсөв

батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 61,6 сая төгрөг буюу 99,9 хувьтай зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн Тус байгууллагын аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 36 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлж, мэдээлээгүй мэдээлэл байхгүй, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд зөвлөмж аваагүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,336,950.00</u>	<u>5,685,426.00</u>
33	АВЛАГА	00.00	96,976.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	96,976.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,336,950.00	5,588,450.00
351	Түүхий эд материал	3,040,000.00	3,040,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,040,000.00	3,040,000.00
354	Хангамжийн материал	1,296,950.00	2,548,450.00
35410	Бичиг хэргийн материал	220,000.00	220,000.00
35420	Аж ахуйн материал	1,076,950.00	2,328,450.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,492,110.93</u>	<u>1,052,999.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,492,110.93	1,052,999.84
392	Биет хөрөнгө	1,492,110.93	1,052,999.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,000,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-763,888.95	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,000.00	90,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,000.00	-72,000.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,850,000.00	1,850,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-630,000.12	-815,000.16
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,829,060.93</u>	<u>6,738,425.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,796.00</u>	<u>350,127.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,796.00	350,127.00
413	Өглөг	7,796.00	350,127.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,796.00	350,127.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,821,264.93</u>	<u>6,388,298.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,821,264.93	6,388,298.84
511	асгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,041,500.00	15,041,500.00
51101	Өмч: - төрийн	15,041,500.00	15,041,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	-9,220,235.07	-8,653,201.16
51210	Өмнөх үеийн үр дүн	-9,220,235.07	-9,220,235.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	567,033.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,829,060.93</u>	<u>6,738,425.84</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>54,095,200.00</u>	<u>61,737,400.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>54,095,200.00</u>	<u>61,737,400.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,295,200.00	55,737,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,295,200.00	55,737,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>54,032,662.72</u>	<u>61,017,588.38</u>

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,032,662.72	61,017,588.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,381,632.72	60,968,816.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,454,523.00	40,756,434.00
210101	Үндсэн цалин	38,454,523.00	40,756,434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,706,824.00	4,790,344.00
210201	Тэтгэврийн даатгал	3,706,824.00	4,790,344.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,769,896.00	2,630,735.00
210401	Бичиг хэрэг	2,591,920.00	772,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,036,680.00	1,174,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,396.00	94,485.00
210404	Ном, хэвлэл	53,900.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	588,500.00
2105	Нормативт зардал	1,916,373.00	00.00
210502	Хоол, хүнс	349,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,566,873.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,302,000.00	990,000.00
210702	Дотоод албан томилолт	1,302,000.00	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,889,700.00	6,039,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,889,700.00	6,039,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,342,316.72	5,762,303.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,972,650.00	4,239,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,236,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	369,666.72	286,333.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	651,030.00	48,772.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	48,772.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	48,772.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,030.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,030.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62,537.28	719,811.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	152,777.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	152,777.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-152,777.71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62,537.28	567,033.91

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	54,095,200.00	61,737,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	54,095,200.00	61,737,400.00

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,800,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,800,000.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,295,200.00	55,737,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,295,200.00	55,737,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	54,095,200.00	61,737,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,095,200.00	61,737,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,444,170.00	61,688,628.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,145,119.00	40,466,195.00
210101	Үндсэн цалин	38,145,119.00	22,890,449.00
210104	Урамшуулал	00.00	11,045,516.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	6,530,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,062,432.00	4,843,505.00
210201	Тэтгэврийн даатгал	4,062,432.00	3,268,205.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	393,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	315,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	78,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	787,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,781,496.00	1,850,518.00
210401	Бичиг хэрэг	572,520.00	403,500.00
210402	Тээвэр, шатахуун	927,480.00	1,004,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	122,396.00	442,708.00
210404	Ном, хэвлэл	159,100.00	00.00
2105	Нормативт зардал	2,026,073.00	00.00
210502	Хоол, хүнс	349,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,676,573.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,840,000.00
210602	Тавилга	00.00	1,840,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,022,000.00	990,000.00
210702	Дотоод албан томилолт	1,022,000.00	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,309,700.00	6,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,309,700.00	6,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,097,350.00	5,698,410.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,097,350.00	4,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	998,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	651,030.00	48,772.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,030.00	48,772.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,030.00	48,772.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
----	---	-------	-------

1.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,041,500.00	00.00	-9,220,235.07	00.00	5,821,264.93
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,041,500.00	00.00	-9,220,235.07	00.00	5,821,264.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,041,500.00	00.00	-9,220,235.07	00.00	5,821,264.93
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	567,033.91	00.00	567,033.91
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,041,500.00	00.00	-8,653,201.16	00.00	6,388,298.84

1.18.Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,295,200.00	52,249,170.00	55,737,400.00	55,688,628.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,295,200.00	52,249,170.00	55,737,400.00	55,688,628.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,695,200.00	51,649,170.00	55,737,400.00	55,688,628.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,101,800.00	38,145,119.00	40,455,100.00	40,466,195.00
210101	Үндсэн цалин	38,101,800.00	38,145,119.00	22,012,300.00	22,890,449.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	11,242,800.00	00.00
210104	Урамшуулал	00.00	00.00	00.00	11,045,516.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	7,200,000.00	6,530,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,110,700.00	4,062,432.00	4,854,600.00	4,843,505.00
210201	Тэтгэврийн даатгал	4,110,700.00	4,062,432.00	4,854,600.00	3,268,205.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	393,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	315,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	00.00	78,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	787,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,781,200.00	1,781,496.00	1,877,700.00	1,850,518.00
210401	Бичиг хэрэг	552,000.00	572,520.00	416,700.00	403,500.00
210402	Тээвэр, шатахуун	929,200.00	927,480.00	1,017,400.00	1,004,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00	122,396.00	443,600.00	442,708.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	1,850,000.00	1,840,000.00

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210602	Тавилга	00.00	00.00	1,850,000.00	1,840,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,039,000.00	1,022,000.00	1,000,000.00	990,000.00
210702	Дотоод албан томилолт	1,039,000.00	1,022,000.00	1,000,000.00	990,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4100000.00	4097350.00	5700000.00	5698410.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,100,000.00	4,097,350.00	4,700,000.00	4,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	1,000,000.00	998,410.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	55,737,400.00	55,688,628.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	55,737,400.00	55,688,628.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	55,737,400.00	55,688,628.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	03.00	03.00	04.00	04.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	02.00	02.00